




Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

► Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн нөхцөл

Чанарын судалгааны дүн



► Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн нөхцөл

Чанарын судалгааны дүн

© Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага 2024

Анхны хэвлэл 2024



Attribution 4.0 International (CC BY 4.0)

Энэхүү судалгааны тайланг Creative Commons Attribution 4.0 Олон улсын тусгай зөвшөөрлийн хүрээнд олон нийтэд нээлттэй байршуулсан болно (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>). Тусгай зөвшөөрлийн хүрээнд уг тайланг дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх боломжтой. Ингэхдээ ОУХБ-ыг хэвлэлийн анхны хувилбарыг эзэмшигч гэдгийг тодорхой тусгаж өгнө. Дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх тохиолдолд ОУХБ-ын логог ашиглахыг хориглоно.

Зохиогч – Судалгааны тайланг дараах байдлаар эшлэнэ: *Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн нөхцөл: Чанарын судалгааны дүн, Улаанбаатар: Олон улсын хөдөлмөрийн товчоо, 2024. © ILO.*

Орчуулга – Тайланг орчуулсан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулсан байх ёстой: *Энэ нь ОУХБ-ын зохиогчийн эрх бүхий бүтээлийн орчуулга юм. ОУХБ нь энэхүү орчуулгыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-ын албан ёсны орчуулга биш юм. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд орчуулан гаргасан зохиогчид бүрэн хариуцна.*

Өөрчлөлт – Тайлангийн агуулгыг өөрчлөн гаргасан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулна: *Энэхүү бүтээл нь ОУХБ-аас гаргасан зохиогчийн эрх бүхий бүтээлийг өөрчлөн боловсруулсан хувилбар юм. ОУХБ нь энэхүү хувилбарыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-аас албан ёсоор өөрчлөн боловсруулсан хувилбар биш болно. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд өөрчлөн гаргасан зохиогчид бүрэн хариуцна.*

Гуравдагч талын материал – Энэхүү тусгай зөвшөөрөл нь тайланд тусгагдсан ОУХБ-ын бус зохиогчийн эрхтэй хэсэгт хамаарахгүй. Хэрэв тус хэвлэлд эшлэгдсэн гуравдагч талын зохиогчийн эрх бүхий материалыг ашиглах бол эзэмших эрх болон аливаа зөрчлийн асуудлаар зөвхөн тухайн зохиогчид хандана.

Тусгай зөвшөөрлийн дагуу үүссэн, эвийн журмаар шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссын Арбитрын журмын дагуу арбитрын шүүхэд шилжүүлнэ. Маргааныг арбитрын шүүх эцэслэн шийдэх бөгөөд талууд шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

Зохиогчийн эрх болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой аливаа асуудлаар ОУХБ-ын Хэвлэлийн албанд (Зохиогчийн эрх ба тусгай зөвшөөрөл) rights@ilo.org хаягаар хандана уу. ОУХБ-ын хэвлэл болон дижитал бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой: www.ilo.org/publns.

ISBN: 9789220416624 (веб PDF)

Энэхүү тайлангийн англи хэл дээрх хувилбар: Working conditions in prisons in Mongolia: Results from qualitative research, ISBN: 978-92-2-040867-4 (веб PDF)

ОУХБ-ын мэдээллийн сан, хэвлэлд ашиглагдсан материал нь НҮБ-ын зарчимд нийцсэн бөгөөд ОУХБ-ын аливаа улс орон, нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал, эрх мэдэл, эсвэл тэдгээрийн хил хязгаарын талаарх илэрхийлсэн байр суурь, илэрхийлэл биш болно.

Хэвлэлд тусгагдсан үзэл, санаа бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд ОУХБ-ын үзэл, санаа бодол, эсвэл бодлого биш юм.

Байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг эш татах нь ОУХБ-аас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн гэсэн утгыг илэрхийлэхгүй. Мөн бусад байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь хүлээн зөвшөөрөөгүйн шинж биш юм.

Энэхүү судалгааны тайланг Европын холбооны санхүүжилтээр ОУХБ-ын хэрэгжүүлж буй “Зохистой хөдөлмөр ба худалдаа” төслийн дэмжлэгтэйгээр орчуулав. Тус тайлангийн агуулга нь Европын холбоо болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй болно.

Уг хэвлэлийг АНУ-ын Хөдөлмөрийн Департаментаас IL-39460-22-75-K- дугаартай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэв. Холбооны нөөцийн сангаас 100 хувь санхүүжүүлж буй олон улсын төслийн нийт төсөв 9.650.000 доллар. Энэхүү материал нь АНУ-ын Хөдөлмөрийн Департаментын үзэл бодол, бодлогыг илэрхийлээгүй бөгөөд аливаа худалдааны нэршил, арилжааны бүтээгдэхүүн, байгууллагыг дурдсан нь АНУ-ын Засгийн газар тэдгээрийг хүлээн зөвшөөрснийг илтгэхгүй болно.

► Агуулга

► Талархал	iv
► Өмнөтгөл	v
► 1. Судалгааны арга зүй	1
► 2. Ерөнхий шинж	2
► 3. Ажлын шинж чанар	4
► 4. Хөдөлмөрийн нөхцөл	8
4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	8
4.2. Ажлын цаг	10
4.3. Цалин, урамшуулал	10
► 5. Дүгнэлт	13
► Хавсралт: Ярилцлага хийх удирдамж	15

► Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгааны хамрах хүрээ, оролцогчид	1
Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ерөнхий шинж	3
Хүснэгт 3. Ажлын байршил ба ажил хийхийг өөрөө зөвшөөрсөн эсэх	4
Хүснэгт 4. Хорих ангиас гадуур ажил хийсэн хоригдлуудын ажил олгогчийн талаарх мэдээлэл	7

► Талархал

Энэхүү судалгааны тайланг Үндэсний судалгаа, зөвлөгөөний төв (ЭН АР СИ СИ) боловсруулж, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан хэлтсийн бодлогын судлаач Мария Габриелла Бреглиа хянав.

Тайланг хэвлэн нийтлэх ажлыг Лилиана Кастилло Рубио (ОУХБ-ын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан хэлтэс) удирдаж, Библиофайлз компанийн Мэй Хофман (ОУХБ-ын зөвлөх) англи хэл дээрх эхийг хянан тохиолдуулж, Роми Канаширо уг эхийг хэвлэлд бэлтгэв.

ОУХБ-ын энэхүү судалгааг АНУ-ын Хөдөлмөрийн департаментаас “Судалгаа, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлж, үр дүнг бодлогод тусгах замаар хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн эсрэг арга хэмжээг эрчимжүүлэх нь” (MAP16 төсөл, GLO/18/29/USA) төслийн IL-30147-16-75-K-11 дугаартай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэв.

Энэхүү хэвлэл АНУ-ын Хөдөлмөрийн Департаментын байр суурь, бодлогыг илэрхийлээгүй бөгөөд аливаа худалдааны нэршил, арилжааны бүтээгдэхүүн, байгууллагыг дурдсан нь АНУ-ын Засгийн газар тэдгээрийг хүлээн зөвшөөрснийг илтгэхгүй болно.

► Өмнөтгөл

Монгол Улс нь Албадан хөдөлмөрийн тухай ОУХБ-ын 1930 оны 29 дүгээр конвенц, Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенцод нэгдэн орсон бөгөөд эдгээр конвенцод хоригдлын хөдөлмөрт тавигдах нөхцөл, шаардлагыг тусгайлан заасан байдаг. Хоригдлын хөдөлмөрийг зөв зохион байгуулж, хоригдол өөрөө сайн дураар зөвшөөрөн мэргэжил эзэмшиж, хөдөлмөр эрхэлбэл чадамж нь сайжирч, суллагаад ажилд ороход дөхөм болох зэрэг ашиг тустай. Харин шүүхийн шийдвэрээр хорих ял оноосон хоригдлыг төрийн хяналтаас гадуур, хувь хүн, компани, нийгэмлэгийн мэдэлд өгч ажиллуулах нь ОУХБ-ын 29 дүгээр конвенцыг зөрчиж байгаа явдал юм.

ОУХБ, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) хамтран 2024 онд Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөр, ял эдэлж байгаа хүмүүсийн хөдөлмөрийн нөхцөл нь ОУХБ-ын 29, 105 дугаар конвенцод нийцэж буй эсэхийг үнэлэх зорилгоор судалгаа хийсэн юм. Уг судалгааны хүрээнд 2021-2022 онд Монгол Улсын 21 хорих ангийн 11-д нь хүрч мэдээлэл цуглуулсны дотор нээлттэй, хаалттай хорих ангийн хоригдлууд, бүх насаараа хоригдох ялтай болон насанд хүрээгүй хоригдлууд хамрагдсан байна. Судалгааны дүнгээс харахад хууль тогтоомж, тусгайлан зохицуулалтад ахиц дэвшил гарсан байна. Хоригдлуудын дийлэнх олонх (92 хувь) нь хөдөлмөр эрхэлж байгаа, ингэхдээ олонх нь сайн дураар ажиллаж байгаа гэж хариулжээ. Гэхдээ ажил хийсэн хоригдлуудын ердөө 55 хувь нь хорих ангитай, эсвэл ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. Ярилцлага хийсэн хоригдлуудаас цөөнх (6.4 хувь) нь хорих ангиас гадуур хувийн аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр ажилласан байна. Ийнхүү гадуур ажил хийсэн хоригдлуудын олонх (89 хувь) нь хорих ангийн албан хаагчийн хяналт дор ажиллажээ. Гэсэн ч хувийн байгууллагын харуулын хяналтад ажиллуулсан (1 хувь), хяналтыг хувийн байгууллагатай хамтран тавьсан (7.8 хувь) тохиолдол байгаа нь 29 дүгээр конвенцтой нийцэхгүй байгааг анхаарах шаардлагатай.

Энэ удаагийн чанарын судалгаа нь одоо ял эдэлж буй хүмүүстэй харьцуулахад үзэл бодлоо илүү чөлөөтэй илэрхийлэх боломжтой гэдэг утгаар ял эдэлж байгаад суллагдсан хүмүүсээс авсан мэдээллээр дээрх судалгааны үр дүнг баяжуулахад чиглэсэн болно. Судалгаанд шүүхээс ял шийтгүүлж, хорих ял эдэлж байгаад суллагдсан 20 хүнийг сонгон дэлгэрэнгүй ярилцлага хийсэн юм. Газар зүйн өөр өөр байршлыг хамруулахын тулд судалгааны баг (хотын төвийн) Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, мөн (хотын захын) Сонгинохайрхан дүүргийн нийт долоон хорооны¹ нийгмийн ажилтантай хамтран ажиллав. Улаанбаатараас өөр, тухайлбал, Өмнөговь аймгаас хүмүүсийг судалгаанд оролцуулах гэсэн боловч амжилтгүй болсон юм. Судалгааны талаарх мэдээлэл (судалгааны зорилго, хэн оролцох боломжтой, хэрхэн холбоо барих)-ийг тухайн нэгжид бүртгэлтэй иргэдэд хүргэх, судалгаанд оролцогчидтой ярилцлага товлон ажлыг нийгмийн ажилтнуудад хариуцууллаа. Судалгаанд оролцогчдын хүсэлтийг харгалзан ярилцлагыг зөвхөн цахимаар зохион байгуулав.

Ярилцлага авах удирдамжийг боловсруулахдаа хоригдлын хөдөлмөрийн шинж байдал, нөхцөлийг үнэлэх зорилго тавьсан юм. Тухайлбал, ажил үүрэг даалгахдаа ялгаварлан гадуурхаж байсан эсэх, ажлын болон ажлын байрны төрөл, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчийг тодруулахад судалгаагаа чиглүүлсэн болно. Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой асуултууд нь ажлын байрны орчин, нөхцөл,

¹ Хороо нь Улаанбаатар хотын дүүргийн засаг захиргааны нэгж юм.

ажлын цаг, цалин, тэтгэмж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдэлийн талаар мэдэхэд чиглэгдсэн юм.

Судалгаанд цөөн хүн оролцсон учир үр дүн нь нийт хоригдлын нөхцөл байдлыг төлөөлөх чадваргүй болно. Гэсэн хэдий ч гүнзгийрүүлсэн ярилцлагаар цуглуулсан мэдээлэл нь эдгээр хүмүүсийн үзэж туулсан нөхцөл байдлыг гүнзгий ойлгож, хоригдлын хөдөлмөрийг хэрхэн ашиглаж байгааг илүү тодорхой мэдэх боломж олгоно. Нөгөө талаар, энэхүү судалгааны үр дүн нь ОУХБ, ХЭҮК-оос хамтран хийсэн өмнөх тоон судалгааг баяжуулж байгаа юм. Тус чанарын судалгаанаас үзэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсээс шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдож байхдаа ажил хийсэн тохиолдол алга байна. Мөн ажил хаялтад оролцсон, улс төрийн шинжтэй гэмт хэрэг үйлдсэн, хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан үндэслэлээр яллагдсан тохиолдол байхгүй байна. Үүнээс гадна хоригдлууд хорих ангиас гадуур хувийн аж ахуйн нэгж, хувь хүний захиалгаар ажил хийх сонирхол илүү байгаа нь ажиглагдсан бөгөөд учир нь үүнийг тэд хугацаанаас өмнө суллагдах боломж гэж хардаг ба хорих ангид байснаас дээр гэж үздэг. Гэсэн хэдий ч олонх нь ажлын байрны нөхцөл, ажлын цаг, цалин, аюулгүй ажиллагааны талаар сэтгэл дундуур байжээ. Барилгын ажил, мод бэлтгэх, модон эдлэл, сийлбэр хийх ажил аюул, эрсдэл өндөр байсан гэжээ. Ярилцлага өгсөн хоёр ч хүн хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдах хэмжээнд хүнд бэртсэн хүнийг нүдээр үзсэн тухайгаа дурдсан байна. Ийм аюул, эрсдэлээс гадна чийгтэй, тоостой зэрэг эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөтэй орчинд ажиллаж байжээ.

► 1. Судалгааны арга зүй

Энэхүү чанарын судалгаанд өмнө нь хорих ял эдэлж байсан 20 орчим хүнийг хамруулахаар тооцож боловсруулав. Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн олонх нь хоёроос таван жилийн өмнө суллагдсан байсан ба суллагад зургаан 6 жил болж байгаа цөөн хүн байлаа.

Эдгээр хүмүүс хоригдож байх үедээ хийсэн ажлын талаар мэдээлэл цуглуулах зорилгоор гүнзгийрүүлсэн ярилцлага авах удирдамжийг боловсруулж, мэдээллийг 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 3 дугаар сарын 9-ний өдрийн хугацаанд цуглуулав.

Судалгааны баг Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, Өмнөговь аймгийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллаж, тухайн засаг захиргааны нэгжид бүртгэлтэй иргэдэд судалгааны талаарх мэдээлэл (судалгааны зорилго, хэн оролцох боломжтой, хэрхэн холбоо барих)-ийг тараалгасан юм. Зар тарсны дараа судалгааны талаар нэмэлт мэдээлэл авах хүсэлтэй 52 иргэн нийгмийн ажилтнуудтай холбоо барьсан байна.

Эхний удаа холбогдсоны дараа 20 хүн судалгаанд оролцох сонирхолгүй байгаагаа илэрхийлсэн бол 32 иргэн судалгааны багт хандаж, нэмэлт мэдээлэл хүссэн болно (Хүснэгт 1). Гэвч нэмэлт мэдээлэл авсны дараа 12 иргэн судалгаанд оролцохоос татгалзсан юм. Ерөнхийдөө эдгээр иргэд ихэд болгоомжлон, шууд холбоо тогтоохоос цааргалж байв. Судалгааны баг биечлэн уулзах, цахимаар болон утсаар ярилцах аргуудыг санал болгосон юм. Бүх оролцогчид нүүр тулж уулзах, утсаар ярихаас татгалзаж цахим ярилцлагын хэлбэрийг сонгосон болно. Ингэснээр 20 хүнтэй хорих ял эдэлж байхдаа хийсэн ажлынх нь талаар амжилттай ярилцав. Ярилцлага 25-45 минут үргэлжлэв.

► Хүснэгт 1. Судалгааны хамрах хүрээ, оролцогчид


	Дүүрэг							Өмнөговь аймаг	Бүгд
	Сүхбаатар				Чингэлтэй		Сонгинохайрхан		
Хорооны дугаар	9	10	18	20	11	12	24		
Сонирхоогүй	1	3	2	3	1	3	2	5	20
Татгалзсан	3	1	1	2	1	3	0	1	12
Оролцсон	2	3	3	2	4	0	4	2	20
Нийт	6	7	6	7	6	6	6	8	52

Судалгаанд цөөн хүн оролцсон учир үр дүн нь нийт хоригдлын нөхцөл байдлыг төлөөлөх боломжгүй. Гэсэн хэдий ч гүнзгийрүүлсэн ярилцлагаар цуглуулсан мэдээлэл нь эдгээр хүмүүсийн үзэж туулсан нөхцөл байдлыг гүнзгий ойлгож, хоригдлын хөдөлмөрийг хэрхэн ашиглаж байгааг илүү тодорхой мэдэх боломж олгоно.

► 2. Ерөнхий шинж

Хүснэгт 2-т ярилцлага өгсөн хүмүүсийн ерөнхий шинжийг харуулав. Тэдний тэн хагас нь бүрэн дунд боловсролтой, тав нь дээд боловсролтой, гурав нь техник, мэргэжлийн боловсролтой, нэг нь дунд сургуулийн сурагч, нэг нь боловсролгүй байв. Олонх нь Монголд зонхилох ястан болох халхууд байна. Мөн олонх нь нийтийн хэв журам зөрчсөн үйлдэлдээ ял шийтгүүлжээ. Гурван хүн дунд сургуулийн ахлах ангид байхдаа, хоёр хүн дунд сургуулиа дөнгөж төгсөөд,¹ хоёр хүн дээд сургуульд сурч байхдаа ял шийтгүүлсэн аж. Бусад нь ял авахаасаа өмнө янз бүрийн ажил хийж байжээ.

Судалгаанд оролцогчид бүгд хорих ялаар шийтгүүлсэн байв. Шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдож байхдаа ажил хийсэн хүн байхгүй. Бүгд гэмт хэргийн улмаас ял авсан бөгөөд ажил хаялтад оролцсон, улс төрийн хэрэгт холбогдсон, хөдөлмөрийн сахилга бат алдсан үндэслэлээр яллагдсан хүн байхгүй ажээ. Судалгаанд оролцогчдын нэг нь Улсын Дээд Шүүхэд давж заалдах гомдол гаргасан хэдий ч гэмт хэрэгт хилсээр буруутгагдаж, хорих ял авсан гэдгээ хэлсэн байна. Харин хоёр ч хүн ямар ялаар шийтгүүлсэн тухайгаа ярихаас татгалзсан юм.



¹ Нэг нь 16 настайдаа насанд хүрээгүй хүний сургалт-хүмүүжлийн байгууллагад орсон бөгөөд уг судалгаанд хамрагдах үедээ 25 настай байв. Тэрээр насанд хүрээгүй хүний хорих байгууллагад хоёр жил байгаад, дараа нь ердийн хорих ангид нэг жил болжээ. Насанд хүрээгүй хүний хорих байгууллагад байхдаа ажил хийж байсан гэх боловч чухам ямар ажил хийснийг (дотоод аж ахуйн ажил уу, эсвэл эдийн засгийн үйл ажиллагаа юу гэдгийг) тогтоох боломжгүй тул хүүхдийн хөдөлмөрт өртсөн эсэхийг тодорхойлж чадаагүй. Ярилцлага өгсөн хоёр хүн дунд сургуулиа төгсөх гэж байх үедээ буюу 18 настайдаа ял шийтгүүлжээ.

► Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн ерөнхий шинж

No	Нас	Боловсролын түвшин	Ял шийтгүүлсэн гэмт хэрэг	Үндэс, угсаа
1	37	дээд	залилан	бусад
2	30	бүрэн бус дунд	нийтийн хэв журам зөрчсөн	халх
3	26	дээд	мэдээлэл өгөөгүй	халх
4	26	дээд	бусдын биед халдсан	халх
5	21	бүрэн дунд	нийтийн хэв журам зөрчсөн	халх
6	39	боловсролгүй	хүний амь нас хохироосон	бусад
7	24	бүрэн дунд	нийтийн хэв журам зөрчсөн	халх
8	23	техник мэргэжлийн	зам тээврийн осол	халх
9	26	бүрэн дунд	залилан	халх
10	21	бүрэн дунд	нийтийн хэв журам зөрчсөн	халх
11	27	Техник мэргэжлийн	нийтийн хэв журам зөрчсөн	бусад
12	28	дээд	дээрэм	халх
13	25	бүрэн дунд	цахим залилан	бусад
14	32	бүрэн дунд	хүн худалдаалах гэмт хэрэгт хамжигчаар оролцсон	халх
15	22	Техник мэргэжлийн	хутга мэс хэрэглэсэн	халх
16	23	бүрэн дунд	архи хэтрүүлэн хэрэглэсэн	халх
17	23	бүрэн дунд	мэдээлэл өгөөгүй	халх
18	26	дээд	нийтийн хэв журам зөрчсөн, архи хэтрүүлэн хэрэглэсэн	халх
19	24	бүрэн дунд	дээрэм	халх
20	23	бүрэн дунд	бүлэг дээрэм	халх

► 3. Ажлын шинж чанар

Судалгаанд хамрагдсан бүх хүн хорих ангид хоригдож байхдаа ажил хийж байжээ. Тэдний олонх (20-иос 15) нь хорих ангийн удирдлагаас даалгасны дагуу ажил хийсэн байна (Хүснэгт 3). Таван хүн өөрийн хүсэлтээр ажил хийсэн гэж хариулжээ. Ажил хийж байгаад дундаас нь больсон эсэхийг асуухад өгсөн хариултаас илүү тодорхой дүр зураг харагдана. Цаанаас даалгасны дагуу ажиллаж байсан гэх 15 хүнээс долоо нь ажлаа болих, татгалзах боломжгүй, шийтгэл хүлээх байсан гэж хариулжээ. Шийтгэлд зодож цохих, хоолноос хасах, эргэлтээр ирсэн ар гэрийнхэнтэйгээ уулзахыг хориглох зэрэг орж байна.

► Хүснэгт 3. Ажлын байршил ба ажил хийхийг өөрөө зөвшөөрсөн эсэх

	Хоригдлын тоо	Ажилласан шалтгаан	Хоригдлын тоо
Хорих ангиас гадуур	14	Үүрэг өгснөөр	12
		Сайн дураар	2
Хорих анги дотор	6	Үүрэг өгснөөр	3
		Сайн дураар	3

Дээр дурдсанаас бусад хоригдол, мөн өөрийн хүсэлтээр ажил хийсэн хоригдлууд ажил хийж байгаад болих буюу ажлаас татгалзах сонирхолгүй байсан гэжээ. Ажил хийхээ болихоор хугацаанаас өмнө суллагдах, мөн хорих ангиас гадуур байх боломжоо алдана гэж үздэг. Энэ нь ихэнх хоригдлын хувьд илүү чухал аж. Хоригдлын ажилласан байдлыг харгалзан хугацаанаас өмнө суллах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 223 дугаар зүйл (Хоригдлыг урамшуулах) болон 224 дүгээр зүйл (Хоригдолд шагналын хоног олгох)-д зохицуулсан байна.

►► Намайг гал тогоонд ажиллуулахаар хуваарилсан. Гал тогоо халуун, тэгээд бас өдөржин зогсоо ажилладаг болохоор ажлын нөхцөл хүнд, зүрхэнд ачаалал өгч, амьсгал давчиддаг байсан. Зүрхний асуудлаасаа болоод би эмчийн хяналтанд байсан. Энэ байдлаа эмчтэй яриад, ажлаа өөрчилсөн. Харин харгалзагч намайг өрөөндөө дуудаад, баашиллаа гэж цохьсон.”

■ Би ч, бусад хоригдол ч ажиллаж байгаад дундаас нь больж, татгалзаж байсан удаагүй. Хэрэв больчихвол дахиад ажил олдохгүй, тэгээд хугацаанаас өмнө суллагдах боломжоо алдана гэж айдаг байсан. Тэгээд бас хорих анги дотор стресс ихтэй, таагүй байдаг болохоор гадуур байж, ажил хийх нь хамаагүй дээр. Бэртэж гэмтсэн ч түүнийгээ нууж байгаад ажил хийдэг байсан.”

Хоригдолд ажил хуваарилахдаа үндэс угсаа, шашин шүтлэгээр нь ялгаварлаж харьцсан тохиолдол байхгүй хэдий ч ар гэрийн байдал, бие бялдарын онцлог, хоригдсон хугацаа зэргийг харгалзан ялгавартай ханддаг байна. Ярилцлага өгсөн хүмүүсийн бараг тал хувь нь ар гэрийн байдлаас болж ялгаварлах хандлага байдаг гэдгийг тодорхой хэлжээ. Тэдний хэлснээр ар гэр нь баян чинээлэг бол өөрөөр ханддаг, арай хөнгөн ажил өгдөг аж. Мөн ар гэр нь баян чинээлэг бол ямар ч ажил хийхгүй байж байгаад хугацаанаас өмнө суллагдах боломжтой гэж зарим нь ярьсан байна.

Судалгаанд хамрагдсан хэд хэдэн хүн биеийн тамир тэнхээ, хорих ангид хоригдсон хугацаанаас шалтгаалан ялгаварлаж харьцах байдлыг нүдээрээ үзсэн гэв.

■ Бие хаа нь ямар байна вэ гэдгээс хамаарч ялгаварлана. Намайг өндөр биетэй, тэнхээтэй болохоор дандаа хүнд хүчир ажилд явуулдаг байсан. Надад хэцүү байсан.”

■ Хоригдоод удаж байгаа хоригдлууд харгалзагч нартай дажгүй харилцаатай болсон байдаг. Тэгэхээр тэд ажлын арай биед хөнгөнийг нь хийнэ, ажлын завсраар амарна.”

Ярилцлага өгсөн хүмүүсийн талаас илүү хувь (12) нь хоригдож байхдаа ажил хийх нь давуу талтай гэж үзсэн байна. Үүнд хугацаанаас өмнө суллагдах боломж бүрдэнэ, орлого олно, гадуур байхад илүү тайван, цаг хурдан өнгөрнө, ажлын туршлагатай болно хэмээн дурджээ. Олонх нь хугацаанаас өмнө суллагдах боломжийг давуу тал гэж үзсэн байна. Ажил хийх нь давуу талтай гэж хэлсэн хүмүүсийн ес нь хоригдож байхдаа ажил хийснээр суллагдсаны дараа ажил олоход дөхөмтэй байсан гэж ярьжээ. Яагаад дөхөмтэй байсан бэ гэхээр илүү туршлагатай, тэсвэр тэвчээртэй, ур чадвар сайтай болсон гэв. Мөн хоёр ч хүн суллагдсаныхаа дараа хориход хийж байсан ажлаа хийж байгаагаа хэлжээ.

Судалгаанд оролцогчид нийт 22 төрлийн ажил хийсэн байна. Тэдний олонх (13) нь нэгээс дээш ажил хийсэн байна. Нийт 20 хүнээс гурав нь хамгийн олон буюу таван өөр төрлийн ажил хийж байсан бол долоо нь хоригдож байх хугацаандаа нэг л төрлийн ажлаар дагнажээ.

Хамгийн нийтлэг ажил нь барилга (9), мод бэлтгэл, модон эдлэл үйлдвэрлэл (5), газар тариаланд (5) байна. Бусад ажлын төрөлд цэвэрлэгээ, зам барилга, мал аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэл, нүүрс савлагаа, оёдол, модон сийлбэр орж байна. Үер, гал түймэр зэрэг онцгой байдлын нөхцөлд ажилласан нэг тохиолдол байлаа. Мөн өдөрт нэг цаг хийдэг, хүнд хүчир биш энгийн нэг ажил хийсэн нэг тохиолдол дурдагдсан байна.

Ярилцлага өгсөн хүмүүсээс ял эдэлж байхдаа хорих ангиас гадуур ажиллаж байсан эсэхийг асуухад олонх нь хорих ангиас гадуур ажилласан гэж хариулжээ (Хүснэгт 4). Гадуур барилга, газар тариалан, мод бэлтгэл, модон эдлэл үйлдвэрлэлийн ажилд оролцсон байна. Хорих ангиас гадуур ажил хийсэн гэж хэлсэн 14 хүний зургаа нь хувийн аж ахуйн нэгж, хувь хүнд ажилласан байна. Зарим тохиолдолд хэнд ажил хийж өгч байгаагаа мэдээгүй өнгөрдөг. Учир нь харгалзагч нар нь хэлж өгдөггүй байна. Жишээ нь, судалгаанд хамрагдсан зургаан хүн хувийн аж ахуйн нэгж, хувь хүнд ажиллаж буй эсэхээ сайн мэдэхгүй өнгөрөх тохиолдол гарч байсан гэж хариулжээ. Харин таван хүн хувийн аж ахуйн нэгжид ажиллаж байгаагүй гэсэн бол нэг хүн хувь хүнд ажил гүйцэтгэсэн байна. Дөрвөн хүн нийтийн зориулалттай барилга, онцгой байдлын үеийн ажил зэрэгт оролцож байжээ.

Хорих ангиас гадуур ажилласан зургаан хүн зарим ажлыг ямар байгууллага хийлгэсэн талаар тодорхой мэдэхгүй байв. Тэдгээр нь голдуу авто зам барилгын ажил байжээ. Монгол Улсад авто зам барилгын салбарт төрийн болон хувийн өмчийн компаниуд аль аль нь үйл ажиллагаа явуулдаг учраас замын ажлыг хувийн, эсхүл улсын аж ахуйн нэгжийн алинд нь гүйцэтгэснийг ялгаж тогтооход хүндрэлтэй. Хорих ангиас гадуур хийсэн зарим ажил, тухайлбал, газар тариалан, мод бэлтгэх ажил нь заримдаа хорих ангийн өөрийн хэрэгцээг, заримдаа хувийн компанийн хэрэгцээг хангах зорилготой байдаг байна.

►► Модон болон төмөр эдлэл хийж борлуулдаг үйлдвэр, мужаан цехүүд байсан. Бас зарж борлуулах зорилгоор тоосго үйлдвэрлэдэг барилгын материалын үйлдвэр байсан. Эдгээр нь том компаниуд ажиллуулдаг үйлдвэр шиг л байсан.”

►► Бид нарын хийсэн гэрийг зарж борлуулдаг байсан юм билээ. Нэг удаа хорих ангийн офицер хувь хүмүүсээс гэрийн захиалга ирсэн гэж ярьж байсан. Тэгэхэд бид нараар гэр хийлгэж зардаг болохыг мэдсэн.”

► **Хүснэгт 4. Хорих ангиас гадуур ажил хийсэн хоригдлуудын ажил олгогчийн талаарх мэдээлэл**

Ажил олгогч байгууллага	Хоригдлын тоо
Хувийн аж ахуйн нэгж	6
Хувь хүн	1
Төрийн байгууллага	4
Тодорхой бус, эсхүл мэдээгүй	6

Тайлбар: Хариултыг давхардсан тоогоор оруулсан тул нийт дүн нь хорих ангиас гадуур ажил хийсэн гэж хариулсан хоригдлын тоо буюу 14-өөс хэтэрсэн байгааг анхаарна уу.

Хоригдлуудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчийн талаар асуухад долоон хүн зарж борлуулдаг байсан гэж эргэлзээгүйгээр хариулсан байна. Судалгаанд хамрагдсан гурван хүн монгол гэрийн мод хийдэг байжээ. Тэдний хэлснээр хорих анги дотор байдаг мужаан цехэд хоригдлууд гэрийг иж бүрнээр нь хийснийг зарж борлуулдаг байсан ажээ.

Судалгаанд оролцсон хоёр хүн тоосго, блок зэрэг барилгын материалыг үйлдвэрлэж байсан гэв. Тэдний хэлснээр хорих анги дотор барилгын материалын үйлдвэр байдаг. Тэр хоёрын нэг нь тоосгыг зарж борлуулдаг гэж тодорхой хэлсэн юм.

Ярилцлага өгсөн хүмүүсээс хоёр нь хорих ангийн ажилтнууд хоригдлыг хувьдаа ажиллуулдаг байсан гэв. Тэдний бэлтгэсэн мод, түлээг хорих ангийн удирдлага хувьдаа хэрэглэдэг байсан гэж нэг нь дурдсан байна. Мөн түүнчлэн хорих ангийн ажилтнууд сийлбэрчин хоригдлуудаар гэрийн эд хогшил, бэлэг дурсгалын зүйл хийлгэдэг байна.

Судалгаанд хамрагдсан бүх хүн хорих анги дотор болон гадуур ажил хийхэд хорихын ажилтан харгалзаж байсныг хэлсэн байна. Тэдний хэлснээр нэг харгалзагч гадуур ажиллаж байгаа гурваас таван хоригдлыг хариуцдаг байна.

►► Би мал аж ахуй дээр ажиллаж байгаад туршлагагүй учир болих гэсэн боловч харгалзагч энэ асуудлыг шийддэг хүн нь чи биш, улсын мөнгөөр тэжээлгэж байж ямар ч ажлыг хийх ёстой гэж хэлж байсан.”

► 4. Хөдөлмөрийн нөхцөл

Судалгаанд хамрагдсан бараг бүх хүний хувьд хөдөлмөрийн нөхцөл хүнд байжээ. Хорих анги дотор оёдлын цехэд ажилласан, мөн өрөө танхимын цэвэрлэгээ, үйлчилгээ хариуцаж байсан хоёр хүн л ажлын байрны нөхцөл сайн байсан гэж хариулсан байна. Мод бэлтгэл, гэрийн мод үйлдвэрлэлд ажиллаж байсан хүмүүс ажлын байрны нөхцөл хүнд байсан гэжээ. Мод бэлтгэхэд ууланд байрлаж, амралтгүйгээр удаан ажиллаж байсан байна. Мод бэлтгэлийн ажил хийж байсан олон хүн өдөрт ганцхан удаагийн хоолтой, тэгээд бие засах газаргүй нөхцөлд ууланд ажиллаж байсан нь хамгийн хэцүү байсныг хэлсэн байна. Гэрийн модны сийлбэр хийдэг байсан хүмүүсийн хувьд мужаан цехийн эрүүл бус нөхцөл хүнд байсан гэв. Тэнд маш их тоостой байсан бөгөөд цехэд ажиллаж байгаа хоригдлуудад хорих ангийн удирдлага маск авч өгдөггүй байжээ.

4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Ярилцлага өгсөн бараг бүх хүн ял эдлэж байх үедээ ажил хийхийн гол сөрөг тал нь ажлын байрны аюултай нөхцөл байсан гэжээ. Хэдийгээр зарим нь ажил хийсэн талаараа эерэг сэтгэгдэлтэй байсан ч бараг бүгд хөдөлмөрийн аюулгүй байдал хангалтгүй байсныг хэлсэн байна. Тиймээс ч олон хүн бага зэргийн гэмтэл, бэртэл авч байсан аж. Түүнчлэн маш хүнд бэртэж, хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдаж байгаа хүмүүсийг харсан болохоо хэд хэдэн хүн ярьсан юм.

Эмнэлгийн үйлчилгээ байдаг ч тухайн ярилцлага өгсөн хүн аль хорих ангид байснаас хамаарч үйлчилгээний чанар, эм, хэрэгслийн хангалт харилцан адилгүй байжээ. Зарим нь хоригдож байхдаа авсан эмнэлгийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байхад нөгөө хэсэг нь эмч нар жижиг гэмтлийг тоодоггүй, зайлшгүй хэрэгцээтэй эм, тариаг өгдөггүй учраас ар гэрийнхэндээ захиж авчруулдаг байсан гэж ярих. Хоригдлууд хүнд бэртэж, хүнд өвчин туссан тохиолдолд эмнэлэгт хэвтүүлдэг байжээ.

Ажлын байрны аюулгүй байдлыг мэдээлж байх ёстой барилга, мужаан цех, үйлдвэрт ажиллагчдаар ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаан дээр тогтмол гарын үсэг зуруулдаг байсан байна. Гэвч ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал хангалтгүй байх нь нийтлэг байжээ. Ярилцлага өгсөн зарим хүний хоригдож байсан ангид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар мэргэшсэн ажилтан ажиллаж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахад хариуцлагатай ханддаг байсан байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн олонх нь, ялангуяа мод бэлтгэл, модон эдлэлийн үйлдвэрлэл, авто зам, барилгад ажиллаж байсан хүмүүс ажлын байранд аюул, эрсдэлтэй тулгарч байсан гэж хэлсэн байна. Хорих ангийн удирдлага, мөн түүнчлэн хоригдлуудыг авч ажиллуулж байсан аж ахуйн нэгж, хувь хүмүүс тэднийг ажлын зохих хувцас, хэрэгслээр хангахгүй байх явдал нийтлэг байжээ.

Ажлын байрны аюул, эрсдэлээс гадна эрүүл мэндэд хортой орчин нөхцөл нь хоригдлууд сүрьеэ, тоосны хүнд хэлбэрийн харшил зэрэг хүнд өвчин тусахад хүргэж байжээ. Ярилцлага өгсөн нэг хүн сүрьеэгийн халдвар авч эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Түүний хэлснээр энэ нь ажлын байр чийгтэй, олон цагаар ажил хийснээс ядарч туйлдахын зэрэгцээ хорих ангийн хоол хүнс тааруу байснаас шалтгаалсан байна. Судалгаанд оролцсон өөр нэг хүн хамт хоригдож байсан хоёр нөхөр нь шинээр баригдаж дууссан орон сууцны цэвэрлэгээ хийж, хүлцэхийн аргагүй тоостой нөхцөлд ажиллаад харшлын хүнд хэлбэрийн урвал илэрч эмнэлэгт хэвтсэн талаар ярьсан байна.

Ажил хийж эхлэхээс өмнө ямар нэг сургалтад хамруулаагүй гэж ярилцлага өгсөн бүх хүн хэлсэн байна. Тусгай чадвар шаардахгүй ажил хийж байсан зарим хүний хувьд сургалт шаардлагагүй байжээ. Тэдний хэлснээр барилгын туслах ажил, ургац хураалт, нүүрс савлагаа, мод бэлтгэх ажилд сургалт шаардлагагүй байсан аж. Зарим хорих ангийн ажилтнууд хоригдлын өмнө хийж байсан ажлын туршлагыг харгалзан тохирох ажлыг хуваарилдаг байжээ. Тусгай ур чадвар шаардсан ажил хийж байсан хүмүүс бусдыг харж байгаад дагаж хийх байдлаар сурдаг байжээ. Хоригдлуудын дунд энэ бол түгээмэл үзэгдэл гэж тэд ярьсан байна. Ярилцлага өгсөн нэг хүн мужаан цехэд бусад туршлагатай ажилчдыг харж байгаад сийлбэр хийж сурсанаа хэлсэн байна.

Ярилцлага өгсөн бүх хүн ажил хийхдээ ямар нэгэн гэрээ байгуулж, гарын үсэг зурж байгаагүй гэдгийг хэлсэн байна. Гарын үсэг зурдаг байсан цорын ганц баримт бичиг нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа байжээ. Заримд нь хийх гэж байгаа ажлын төрөл, ажлын цаг, цалин хөлсний талаар хэлж байсан боловч зарим нь хийх гэж байгаа ажлынхаа талаар ямар ч мэдээлэл авч байгаагүй гэв.

■ ■ Хамгийн хэцүү ажил бол ууланд мод бэлтгэх ажил байсан. Идэж, уух юм хомс. Маш их цангана, өлсөнө. Биднийг ажиллаж байхад хоол авчирч өгдөг байсан тэр настай хүнтэй дахиж уулзвал баярласнаа хэлэхийг хүсдэг. Тэгээд бас бие засах газар байхгүй. Хорих ангийн харгалзагч нар биднийг амраадаггүй байсан.”

■ ■ Хөдөлмөрийн аюулгүй байдал орчин цагт маш чухал асуудал болж байгаа. Гэтэл хорих ангид маш их асуудал байна. Биднийг хэрэгцээтэй багаж, хэрэгслээр ч хангаж байгаагүй. Нүүрс шуудайлах ажилд гаргахдаа 10 хоригдлын дунд ердөө хоёрхон хүрз өгөх жишээтэй. Дээр нь ажлын бээлий огт өгч байгаагүй.”

■ ■ Хоригдож байхдаа ажил хийхэд давуу тал бий. Хугацаанаас өмнө суллагдана. Барилга дээр ажиллаж байгаад бэртсэн тохиолдолд дахиад гадуур ажиллах боломжгүй болохоос айгаад бэртэл, гэмтлээ нуудаг байсан. Зарим хоригдол хүнд гэмтлээ ч нуудаг байсан.”

4.2. Ажлын цаг

Судалгаанд хамрагдсан хүмүүс маш олон цагаар ажилладаг байжээ. Нийт 20 хүнээс дөрөв нь л долоо хоногт 5-6 өдөр ажилладаг байсан бол бусад нь долоо хоногийн бүх өдөр ажилласан гэв. Тэд өдөрт дунджаар 10 цаг (хамгийн багадаа нэг цаг, хамгийн ихдээ 18 цаг) ажилласан байна. Зургаан хүн өдөрт 12 цаг ажиллаж байсан гэж ярьжээ.

Дунджаар нэг хүн 15,6 сар ажилласан бөгөөд хоригдсон хугацаанаас хамаараад нэгээс 60 сарын хооронд хэлбэлзэж байна. Ярилцлага өгсөн хүмүүсийн олонх нь хоригдож байх хугацаандаа завсаргүй ажиллаж байсан аж.

■ Бид өдөрт 10 цаг ажилладаг байсан. Ажлын цаг, цалин мөнгөний талаар асуух юм бол хорих ангийн ажилтнууд биднийг ажиллуулахгүй. Тийм болохоор гадуур ажил хийж, хоногоо хасуулахын тулд чимээгүй л байдаг байсан. Хорихоос гадуур ажиллаж байхад цаг хугацаа хурдан өнгөрдөг байсан.”

■ Олон цагаар ажиллах хүнд байсан. Зарим хоригдол сульдаж ядраад ирэхээрээ тоосго зөөж чадахгүй болж байсан. Нэг хоригдол халуурч туйлдсан байхыг харсан. Тэгсэн ч тэр хүн хорих ангийн ажилтнууд ажиллуулахгүй болчихно гэж айгаад хэнд ч мэдэгдэхгүйг хичээж байсан. Ажил хийх нь хоригдлуудын хувьд маш чухал байдаг.”

4.3. Цалин, урамшуулал

Судалгаанд оролцогч нарын дунд цалин хөлстэй ажил хийсэн дөрөвхөн тохиолдол (сард 300,000- 600,000 төгрөг) байгаагаас үзвэл хоригдлын хөдөлмөр үндсэндээ хөлсгүй хөдөлмөр гэж дүгнэж болохоор байна. Ярилцлага өгсөн 20 хүнээс ес нь хийсэн ажлынхаа хөлсийг авч чадаагүй. Зарим нь сард 20,000 төгрөг, гурван сарын хугацаанд 35,000 төгрөг гэх мэт багахан мөнгө авсан байна.

Ажил хийх хамгийн гол хөшүүрэг нь хугацаанаас өмнө суллагдах боломж юм. Ярилцлага өгсөн зарим хүний хэлснээр хоригдол нэг сар ажиллахад ялынх нь хугацаанаас 10 хоног хасагддаг. Энэ бол зөвхөн хөнгөн ялтай хоригдолд хамаарна. Хэрэв хоригдол сахилгын зөрчил гаргавал хорих ангийн эрх бүхий этгээд хасагдсан хоногийг цуцалж болдог. Ярилцлага өгсөн есөн хүн хоригдож байхдаа ажил хийсний хүчинд хугацаанаас өмнө суллагдсан гэв. Хоёр хүн хамт хоригдож байгаа хүмүүстэйгээ зөрчилдсөний улмаас энэ боломжоо эдэлж чадаагүй байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүс цалин, урамшууллын талаар мэдэхгүй байх нь нийтлэг байв. Заримд нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин өгнө гэсэн ч яг олгохдоо хавьгүй бага мөнгө өгчээ. Хугацаанаас өмнө суллагдах боломжийг ч тэр бүр мэдэхгүй байв. Зарим нь ажил хийгээд хэдэн хоног хасуулсан тухайгаа тодорхой ярьж байхад нөгөө хэсэг нь сайн мэдэхгүй байлаа.

▲▲ Ажил хийх сонирхол төрүүлдэг хамгийн гол зүйл бол хугацааны өмнө суллагдах боломж байдаг. Би хоригдож байхдаа ажил хийсний шагналд хугацаанаас таван сарын өмнө суллагдсан. Миний хувьд энэ нь маш чухал байсан. Хорих ангийн ажилтнууд хоригдлоос ажил хиймээр байна уу, үгүй юу гэж асуух шаардлагагүй. Хоригдлууд эрт гарахын тулд бүгдээрээ л ажил хийхийг хүсдэг.”

▲▲ Би хоригдож байхдаа барилга дээр цалингүй ажиллаж байсан. Суллагдсаны дараа яг тэр ажлаа хийгээд өдөрт 180,000 төгрөг авч байсан.”

▲▲ Би сайн ажиллаад, томоотой байвал шагналд нь эрт суллагддаг гэдгийг мэдээгүй байсан. Надад ч ийм боломж байсан юм билээ. Нэг хоригдолтой зодоон хийгээд, сахилгын шийтгэл авсны дараа л ийм боломж байдгийг мэдсэн. Надад хэлэхгүй яав даа гэж бодсон. Хорих ангийн удирдлага ажлын нөхцөл, болзлын талаар ойлголттой байх хэрэгтэй. Тэгээд бидэнд ажил хийх бүх л боломж, давуу талыг хэлж өгдөг байх хэрэгтэй.”

Ярилцлага өгсөн хүмүүсийн олонх нь хоригдож байх үедээ ажил хийсэн талаараа эерэг сэтгэгдэлтэй байв. Тэдний бодлоор ажил хийснээр шинэ ур чадвар олж авдаг, сэтгэл санаа тайван байдаг, цалин хөлс авдаг, мөн амьдралын шинэ туршлага хуримтлуулдаг байна. Гэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, цалин хөлс, ажлын цагийг тодорхой тогтоодог байх, шаардлагатай сургалтад хамруулах гэх мэтээр сайжруулах шаардлагатай зүйлс байжээ. Ярилцлагын үед хоригдол хөдөлмөр хийх нь зүйтэй гэж үздэгээ хэлсэн хүмүүсийн олонх нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах шаардлагатайг дурдсан байна.

Ярилцлага өгсөн хүмүүсээс хоёр хүн л ажил хийх хүсэлгүй байсан гэдгээ хэлжээ. Тэд ажил хийлгэхийн оронд сургалт, зөвлөгөөнд илүүтэй хамруулдаг байвал зүгээр гэж үзсэн байна. Хоригдлуудыг хоригдож байх хугацаанд нь суллагдсаны дараах амьдрал, ажил хөдөлмөрт нь бэлтгэх хэрэгтэй гэжээ.

Ярилцлага өгсөн хүмүүсээс хувийн аж ахуйн нэгж, хувь хүний захиалгаар ажилд гаргахдаа хоригдлоос саналыг нь асуух ёстой гэдгийг мэдэж байсан уу гэж асуусан юм. Хувийн аж ахуйн нэгж, хувь хүний санал болгосон ажлыг хийх үү гэж хоригдлуудаас зөвшөөрлийг нь авдаг байсан гэж зөвхөн нэг хүн л хариулсан байна. Хоёр хүн хоригдлын эрхийн талаар мэдээлэл авснаа хэлсэн байна. Тэдний нэг нь ХЭҮК-оос зохион байгуулсан сургалтаас мэдээлэл авсан бол нөгөө нь хорих ангийн ажилтнаас мэдэж авчээ. Ярилцлага өгсөн дөрвөн хүн хоригдохоосоо өмнө эрхээ мэддэг байсан гэв. Гэвч тэдний хэлснээр эрхээ мэдээд ч хоригдож байгаа болохоор ямар ч арга байхгүй гэжээ. Ярилцлага өгсөн бусад хүн аж ахуйн нэгж, хувь хүний санал болгосон ажлыг хийх эсэхийг хоригдлоос асуух ёстой, энэ бол тэдний эрх гэдгийг мэдэхгүй гэж хариулсан юм. Заримынх нь хэлснээр хувийн аж ахуйн нэгж, хувь хүнд ажиллах нь хоригдлуудын дунд эрэлт маш ихтэй байдаг аж. Учир нь цалин мөнгө авна, бас хорих ангиас гадуур цаг өнгөрөөнө.

■ Би хоригдож байхдаа хувцас оёх ажил хийдэг байсан. Цамц, өмд, бээлий оёж сурсан. Хорих ангид ажиллах явцад шинэ ур чадвар эзэмшиж, хөдөлмөр, бизнесийн харилцааны талаар сурч мэдсэн. Энэ бүхэн хорихоос гарсны дараа ажил олоход дөхөм болсон.”

■ Би залилангийн хэргээр ял авсан. Хорих ангиас суллагдсаны дараа хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлөх ёстой болсон. Уг нь хоригдох хугацаандаа сайн ажиллаад, хохирлын мөнгийг олох боломж олгодог тогтолцоотой байсан бол зүгээр байсан юм. Ажил хийхийн ганц ашиг нь эрт суллагдах. Би энэ боломжийг ашиглаж чадаагүй. Би гурван сарын турш ажиллаад 27,000-аас 35,000 төгрөг л авч байсан.”

► 5. Дүгнэлт

Цөөн хүнээс авсан ярилцлагын үр дүнд тулгуурласан учраас энэхүү судалгааны дүгнэлтийг тайлбарлан хэрэглэхдээ болгоомжтой хандах хэрэгтэй. Гэсэн ч хэдий ч уг судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн нөхцөл байдал ОУХБ-ын 29 болон 105 дугаар конвенцуудын шаардлагад нийцэж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байна.

Судалгаанд оролцогчид бүгд хорих ялаар шийтгүүлсэн байв. Шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдож байхдаа ажил хийсэн хүн байхгүй. Түүнчлэн ажил хаялтад оролцсон, улс төрийн хэрэгт холбогдсон, хөдөлмөрийн сахилга бат алдсан үндэслэлээр яллагдсан хүн байхгүй ажээ. Ажил хийхдээ амаар, эсхүл бичгээр зөвшөөрөл өгч байсан тохиолдол нэг ч байхгүй байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн олонх (15) нь хорих ангийн удирдлагаас даалгасны дагуу ажил хийсэн байна. Харин таван хүн өөрийн хүсэлтээр ажил хийсэн гэжээ. Ажил хийхээс татгалзах боломжгүй, шийтгүүлдэг байсан байна. Шийтгэлд зодож цохих, хоолноос хасах, эргэлтээр ирсэн ар гэрийнхэнтэйгээ уулзахыг хориглох зэрэг орж байна.

Хоригдолд ажил хуваарилахдаа үндэс угсаа, шашин шүтлэгээр нь ялгаварлаж харьцсан тохиолдол байхгүй хэдий ч ар гэрийн байдал, биеийн хүч тэнхээ, хоригдсон хугацаа зэргийг харгалзан ялгавартай ханддаг байна. Ярилцлага өгсөн хүмүүсийн бараг тал хувь нь ар гэрийн байдлаас болж ялгаварлах хандлага байдаг гэдгийг тодорхой хэлжээ.

Ярилцлага өгсөн хүмүүсийн олонх нь хугацаанаас өмнө суллагдах боломжийг ажил хийхийн давуу тал гэж үзсэн байна. Тэдний зарим нь хоригдож байхдаа ажил хийснээр суллагдсаны дараа ажил олоход дөхөмтэй байсан гэжээ. Яагаад дөхөмтэй байсан бэ гэхээр илүү туршлагатай, тэсвэр тэвчээртэй, ур чадвар сайтай болсон гэв. Мөн хоёр ч хүн суллагдсаныхаа дараа хориход хийж байсан ажлаа хийж байгаагаа дурдсан байна. Ажил хийхээр хоригдол сэтгэл санаа тайван байж, цаг хурдан өнгөрдөг гэжээ.

Хамгийн нийтлэг ажил нь барилга, мод бэлтгэл, модон эдлэл үйлдвэрлэл, газар тариаланд байна. Бусад ажлын төрөлд цэвэрлэгээ, зам барилга, мал аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэл, нүүрс савлагаа, оёдол, модон сийлбэр орж байна. Үер, гал түймэр зэрэг онцгой байдлын нөхцөлд ажилласан тохиолдол байна.

Ярилцлага өгсөн хүмүүсийн олонх (20-иос 14) нь хорих ангиас гадуур ажиллаж байжээ. Тэдний зургаа нь хувийн аж ахуйн нэгж, хувь хүнд ажилласан бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь зарж борлуулдаг байжээ. Зарим (6) нь хэнд ажилласнаа мэдэхгүй байлаа. Судалгаанд хамрагдсан бүх хүн хорих ангиас гадуур ажиллахад хорихын ажилтан харгалзаж байсныг хэлсэн байна. Тэдний хэлснээр хорих анги дотор гэрийн мод хийдэг мужаан цех, тоосгоны үйлдвэр ажиллаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зарж борлуулдаг байжээ.

Судалгаанд хамрагдсан бараг бүх хүний хувьд хөдөлмөрийн нөхцөл хүнд байжээ. Хорих анги дотор оёдлын цехэд ажилласан, мөн өрөө танхимын цэвэрлэгээ, үйлчилгээ хариуцаж байсан хоёр хүн л ажлын байрны нөхцөл сайн байсан гэж хариулсан байна. Мод бэлтгэл, гэрийн мод үйлдвэрлэлд ажиллаж байсан хүмүүс ажлын байрны нөхцөл хүнд байсан гэжээ. Мод бэлтгэхэд ууланд байрлаж, амралтгүйгээр удаан ажиллаж байсан байна.

Хоригдлын ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал ноцтой байгаа нь анхаарал татаж байна. Хоёр ч хүн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар мэргэшсэн ажилтан ажиллаж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахад хариуцлагатай ханддаг

байсныг дурдсан байна. Гэвч судалгаанд хамрагдсан хүмүүсийн олонх нь, ялангуяа мод бэлтгэл, модон эдлэлийн үйлдвэрлэл, авто зам, барилгад ажиллаж байсан хүмүүс ажлын байранд аюул, эрсдэлтэй тулгарч байсан гэж хэлжээ. Түүнчлэн хорих ангийн удирдлага, хоригдлуудыг авч ажиллуулж байсан хувийн аж ахуйн нэгжүүд тэднийг ажлын зохих хувцас, хэрэгслээр хангахгүй байх явдал нийтлэг байжээ.

Судалгаанд хамрагдсан хүмүүс маш олон цагаар ажилладаг байжээ. Нийт 20 хүнээс дөрөв нь л долоо хоногт 5-6 өдөр ажилладаг байсан бол бусад нь долоо хоногийн бүх өдөр ажилласан гэв. Тэд өдөрт дунджаар 10 цаг (хамгийн багадаа нэг цаг, хамгийн ихдээ 18 цаг) ажилласан байна. Зургаан хүн өдөрт 12 цаг ажиллаж байсан байна.

Судалгаанд оролцогч нарын дунд цалин хөлстэй ажил хийсэн дөрөвхөн тохиолдол (сард 300,000- 600,000 төгрөг) байгаагаас үзвэл хоригдлын хөдөлмөр үндсэндээ хөлсгүй хөдөлмөр гэж дүгнэж болохоор байна. Ярилцлага өгсөн 20 хүнээс ес нь хийсэн ажлынхаа хөлсийг авч чадаагүй. Зарим нь сард 20,000 төгрөг, гурван сарын хугацаанд 35,000 төгрөг гэх мэт багахан мөнгө авсан байна. Ажил хийхийн ашиг тус нь цалин гэхээсээ илүү эрт суллагдах боломж гэдгийг оролцогчид онцолж байв.

Ярилцлага өгсөн хүмүүсийн олонх нь хоригдож байх үедээ ажил хийсэн талаараа эерэг сэтгэгдэлтэй байв. Тэдний бодлоор ажил хийснээр шинэ ур чадвар олж авдаг, сэтгэл санаа тайван байдаг, цалин хөлс авдаг, мөн амьдралын шинэ туршлага хуримтлуулдаг байна. Гэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, цалин хөлс, ажлын цагийг тодорхой тогтоодог байх, шаардлагатай сургалтад хамруулах гэх мэтээр сайжруулах шаардлагатай зүйлс байжээ.

► Хавсралт: Ярилцлага хийх удирдамж

Энэхүү ярилцлага нь Монгол Улс дахь хорих анги дахь хөдөлмөрийн нөхцөл, хоригдлуудын ажил, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргийг тандан мэдэх зорилготой болно.

Ярилцлагад өгсөн мэдээллийг Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу чандлан нууцлах бөгөөд зөвхөн судалгаа шинжилгээний нэгдсэн дүгнэлт гаргахад ашиглах болно.

Судлаачийн анхаарах зүйлс

- Ярилцлагыг биечлэн уулзаж ярилцах хэлбэрээр явуулах судлаач ярилцлагыг удирдаж, тэмдэглэл хөтөлнө.
- Ярилцлагын үргэлжлэх хугацаа 30-40 минут байна.
- Судлаач ярилцлагыг дуу хураагчид баримтжуулан авна. Ингэхдээ судалгаанд оролцогчид урьдчилан хэлж зөвшөөрөл авсан байна.
- Ярилцлага чөлөөтэй өрнүүлэх боломжтой орчин нөхцөл, цагийг сонгоход судлаач анхаарна.
- Судлаач ярилцлага эхлүүлэхийн өмнө “нүүр хагарах” зорилгоор судалгаанд хамааралгүй асуулт асууж, хариулт авч болно.
- Ярилцлагад оролцогчид асуултад хариулахгүй байж болох бөгөөд ярилцлагыг хүссэн үедээ зогсоож болно

Ерөнхий мэдээлэл

- Ярилцлага хийгдсэн газар
- Судлаачийн нэр
- Ярилцлага хийгдсэн огноо
- Ярилцлага үргэлжилсэн хугацаа

Хоригдлоос авах ярилцлагын чиглэл

Судалгаанд оролцогчийн талаарх мэдээлэл

1. Судалгаанд оролцогчийн талаарх ерөнхий мэдээлэл
 - a. Нас, хүйс, боловсрол?
 - b. Хоригдсон талаарх мэдээлэл, боломжтой бол, ямар гэмт хэргийн улмаас ял шийтгүүлсэн тухай?

Нэмж тодруулах

- i. Хоригдсон талаар: шүүхээр орохгүйгээр захиргааны журмаар хоригдсон/шүүхээс өмнөх шатанд цагдан хоригдсон/хорих ялаар, эсхүл хорихоос өөр ялаар шийтгүүлсэн эсэх?
- ii. Ямар шалтгаанаар: ажил хаялтад оролцсон/улс төрийн хэрэгт холбогдсон/хөдөлмөрийн сахилга зөрчсөн/ялгаварлан гадуурхагдаж?

Ажиллах болсон нөхцөл байдал

1. Хоригдож байхдаа ажил хийж байсан уу?
 - a. Өөрөө ажил хийе гэж хүсэлт гаргасан уу
 - b. Эсхүл удирдлагаас өгсөн үүрэг байсан уу?
 - i. Тухайн ажлыг хий гэж танд үүрэг өгсөн эсхүл уг ажилтай холбоотойгоор таныг үндэс угсаа, шашин шүтлэг, эсхүл өөр ямар нэг тодорхой шалтгаанаар ялгаварласан гэсэн бодол төрж байсан удаа бий юу? (тэр шалтгааныг тайлбарлана уу)
 - ii. Тухайн ажлыг хийхээс татгалзаж болохоор байсан уу?
2. Ажил хийдэг болсноос хойш ажил хийхээ больсон удаа бий юу?
 - a. Хэрэв тийм бол тийнхүү больсон шалтгаан нь юу вэ?
 - b. Ажил хийхээ болих боломжтой юу?
3. Та яагаад ажил хийхээр болсон бэ?
 - a. Ажил хийхэд давуу болон сул тал нь юу вэ?
 - b. Таны бодлоор хоригдож байхдаа ажил хийснээр суллагдсаны дараа ажил олоход дөхөмтэй байсан уу?

Хөдөлмөрийн нөхцөл

1. Та ямар төрлийн ажил хийж байсан бэ? Таны ажил, үүрэг юу байсан бэ?
2. Тухайн ажлыг хийхдээ бичгээр гэрээ байгуулж байсан уу?
 - a. Хэрэв тийм бол та гэрээнд заасан нөхцөл, болзолтой танилцсан уу, гэрээний нөхцөлийг бүрэн гүйцэд ойлгож чадсан уу?
 - b. Гэрээний нөхцөл биелэгдсэн үү?
 - c. Хэрэв та гэрээнд гарын үсэг зураагүй бол хөдөлмөрийн нөхцөл (ажлын цаг, цалин хөлс гэх мэт)-ийн талаар мэдээлэл авсан уу? Уг мэдээллийг хаанаас авсан бэ?
3. Та тухайн ажлыг хаана хийж байсан бэ?
 - a. Нэмж тодруулах: хорих анги дотор/хорих ангиас гадуур

4. Та хорих ангитай гэрээтэй хувийн аж ахуйн нэгж, хувь хүн, төрийн бус байгууллагад ажиллаж байсан уу?
5. Таны ажлын үр дүнд бий болсон бараа бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчийг тодорхойлно уу?
 - a. нэмж тодруулах: тухайн хорих ангид хэрэглэдэг/өөр хорих ангид хэрэглэдэг/зах зээлд борлуулдаг
6. Ажилд гарахаас өмнө ямар нэг сургалтад хамрагдсан уу?
7. Хорих ангиас суллагдсан цагаас хойш өмнөхтэй төстэй ажил хийсэн үү?
8. Хөдөлмөрийн нөхцөл ямар байсан бэ?
 - a. ажлын байрны нөхцөл
 - b. амралт
 - c. хоол хүнс, амрах байр
9. Ажил хийгээд цалин хөлс авч байсан уу? Хэдийг авч байсан бэ? Ямар хэлбэрээр авч байсан бэ?
 - a. цагийн хөлс
 - b. сарын цалин
 - c. хорих газраас суллагдахдаа хадгаламжиндаа хэр их мөнгөтэй байсан бэ?
 - d. бэлэн мөнгөөр, банкны дансаар, эд зүйлээр
 - e. ял хөнгөрүүлэх зэрэг бусад нөхцөл
10. Та ямар хугацаанд ажилласан бэ? Ямар цагийн хуваариар?
 - a. Ямар хугацаанд буюу нийт ажилласан хугацаа?
 - b. Долоо хоногийн хэдэн өдөрт нь ажилласан бэ?
 - c. Өдөрт хэдэн цаг ажилласан бэ?
11. Таныг ажил хийж байхад хэн зааж, чиглүүлж байсан бэ?
 - a. Нэмж тодруулах: хорих газрын ажилтан/өөр бусад этгээд (хэн?)
12. Таны хийж байсан ажил ямар нэг аюул, эрсдэлтэй байсан уу? Хэрэв тийм бол чухам ямар эрсдэл байсан бэ? Бэртэж, гэмтсэн удаа бий юу?
13. Хорих ангийн зүгээс эмнэлгийн тусламж, зөвлөгөө авах боломж байдаг уу? Та авч байсан удаа бий юу?
14. Танд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн үү? Таныг ажлын зориулалтын хувцас, багажаар хангасан уу?
15. Хоригдож байх үедээ ажил хийж байсан бусад хоригдлын талаар та мэдэх үү? Тэдний ажлын талаар ярьж өгнө үү.

- a. ажил, үүргийн талаар
 - b. ажлын байр нь хорих анги дотор, гадуур, хувийн аж ахуйн нэгж, хувь хүн, төрийн бус байгууллагын аль нь болох талаар
 - c. харгалзагчийн талаар
 - d. гэрээний талаар
 - e. цалин хөлсний талаар
 - f. ажлын цагийн талаар
16. Таны бодлоор хорих ангийн хөдөлмөрийн нөхцөл бусад энгийн хүмүүсийн хөдөлмөрийн нөхцөлтэй хахьцуулахад ямар байсан бэ?
- a. ажлын байрны нөхцөл
 - b. цалин хөлс
 - c. мэргэжлийн ур чадвар эзэмших байдал
17. Таны бодлоор хорих ангид хоригдлоор ажил хийлгэх шаардлагатай юу?
18. Хорих ангиас гадуур хувийн аж ахуйн нэгж, хувь хүн, төрийн бус байгууллагад ажиллахад татгалзах зүйл бий эсэхийг танаас асуусан уу? Хорих ангиас гадуур ингэж ажиллах хууль, эрх зүйн талаар та мэдэж байсан үү?

**Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба
эрхийн асуудал хариуцсан хэлтэс**

**Засаглал, гурван талт түншлэлийн
асуудал хариуцсан хэлтэс**

International Labour Office
4 route des Morillons
CH-1211 Geneva 22 – Switzerland
T: +41 (0) 22 799 61 11
E: forcedlabour@ilo.org

► ilo.org/forcedlabour

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага

📍 НҮБ-ын байр 604
Нэгдсэн үндэстний гудамж-12
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201

☎ 976 11 320624

✉ ulaanbaatar@ilo.org

🌐 www.ilo.org/mongolia

📘 ILOMongolia